

ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТОЙРСОН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Л.Баян-Алтай

Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тохиолдож болох аливаа сөрөг нөлөөллөөс ангид байхын тулд зайлшгүй анхааран авч үзвэл зохих асуудлуудыг багтаасан энэхүү товч зөвлөмжийг Нээлттэй Нийгэм Форумаас боловсруулан гаргаж байна.

ОРШИЛ

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны долдугаар сарын 20-ны өдрийн 195-р тогтоолын дагуу Монгол Улсын Хөгжлийн Банкныг байгуулан, улмаар тус оны гуравдугаар улиралд багтаан зохих журмын дагуу үйл ажиллагааг нь эхлүүлэх болсон билээ. Хөгжлийн банк байгуулах шийдвэр ийнхүү гарсан ч өнөөгийн байдлаар олон нийт, татвар төлөгчдийн хувьд маш олон зүйл тодорхойгүй байна. Тус байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэл, санхүүжилтын эх үүсвэр, удирдлага, зохион байгуулалтын талаар иргэд, судалгааны байгууллагууд, иргэний нийгмийн дунд хэлэлцүүлэг явагдсангүй, тэдний санал бодлыг сонссон алхам хийгдсэнгүй гэж хэлэхэд болно.

Олон улсын туршлагаас харахад, тухайн улс орны хөгжилд дорвитой түлхэц болох үйл ажиллагаа, үйлчилгээг хувийн салбар нь дангаараа нийлүүлэх чадавхи хангалтгүй нөхцөлд засгийн газрын дэмжлэгтэй ийм төрлийн санхүүгийн институт байгуулдаг ажээ. “Development Finance Institutions” буюу “Хөгжлийн Санхүүгийн Байгууллага” (ХСБ) гэж нэрлэгддэг эдгээр байгууллагын нэг хэлбэр нь хөгжлийн банк юм. Өнөөдөр дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй 750 гаруй ХСБ байгаа бөгөөд тэднийг үндэсний хөгжлийн банк, хөгжлийн санхүүгийн корпораци, ЭксИм банк, хөдөө аж ахуйн банк гэхчлэн олон янзаар нэрлэдэг. Хөгжлийн банкууд нь нийгэм, эдийн засгийн томоохон үр нөлөө бүхий төслүүдэд урт хугацааны санхүүжилт олгохоос гадна судалгаа, зөвлөх үйлчилгээ болон техникийн туслалцааг ч үзүүлж байна.

Аль нэг улсын хэмжээнд, өөрөөр хэлбэл дотооддоо үйл ажиллагаа явуулдаг хөгжлийн банкныг үндэсний хөгжлийн банк гэх ба энэ нь голдуу аж үйлдвэрлэлийн хөгжлийн эхний үе шатанд байгуулагддаг бөгөөд тухайн орны эдийн засагт онц чухал ач холбогдолтой боловч хувийн хэвшлээс санхүүжүүлэх боломжгүй салбаруудыг урт хугацааны зээл, санхүүгээр хангадаг аж¹. Гэхдээ эдийн засаг, бизнесийн орчин асар их хурдацтай өөрчлөгдөж буй өнөө үед олон орны засгийн газар төрийн хөрөнгөөр үүсэн бий болж, үйл ажиллагаа явуулж ирсэн хөгжлийн банкуудын үүрэг, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог эргэн харахад хүрчээ. Хөгжлийн төлөө гэсэн сайхан зорилго тавин, татвар төлөгчдийн хөрөнгөөр, янз бүрийн хөнгөлөлт эдлэн гарч ирдэг ийм байгууллагуудын хувь заяа муугаар эргэсэн гашуун туршлага олон бий. Нөгөө талаар, өнөөг хүртэл хөгжлийн банкны хувьд нийтээр хүлээн зөвшөөрсөн загвар бүтэц алга байна.

Хэдийгээр тооны хувьд цөөн ч боломжийн амжилттай ажиллаж ирсэн хөгжлийн банкууд бий. Ийм тохиолдолд засгийн газар нь эхнээсээ хөгжлийн банкны хувьд маш ухаалаг, оновчтой механизмыг бий болгож, хууль эрх зүйн орчинг зөв тодорхойлж өгсөн байдаг. Ингэж чадаагүй бол ийм төрлийн санхүүгийн байгууллага нь урт хугацааны туршид тогтвортой ажиллах боломжгүй болж, яваандаа дампууран үйл ажиллагаагаа зогсоохоос аргагүй байдалд хүрдгийг Латин Америк, Африк, Зүүн Азийн зарим орон дахь олон жишээнээс харж болно.

¹ “Evolving role of national development banks in East Asia”, Jennifer Amyx and A.Maria Toyoda, 2006.



Л.Баян-Алтай

Л.Баян-Алтай нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг донор байгууллагуудын санхүүжилттэй, эдийн засгийн хөгжил, хөдөө аж ахуй, бичил зээл, жижиг дунд бизнесийг дэмжсэн төсөл, хөтөлбөрүүдийг удирдан хэрэгжүүлж ирсэн болно. Хөнгөн үйлдвэр, уул уурхайн чиглэлээр хувийн хэвшилд ажиллаж байсан.

Монгол Улсын Техникийн Их Сургууль, Английн Лийдз болон Мичиганы Их Сургуулийг төгсчээ.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Нээлттэй Нийгэм Форум нь 2004 оны зургадугаар сард Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын сан/-г өөрчлөн байгуулсны үндсэн дээр бий болсон Монголын төрийн бус байгууллага юм. Нээлттэй Нийгэм Форумын үндсэн зорилго нь чанартай мэдээлэл, судалгаа, олон талт хэлэлцүүлэгт тулгуурлан төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад иргэдийн идэвхитэй оролцоог дэмжихэд оршино.

ННФ иргэний нийгмийн бусад байгууллагатай нягт түншлэн ажиллахын сацуу парламент, засгийн газартай өргөн хүрээнд хамтран ажилладаг. Мөн улс оронд өрнөж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн үйл явцын талаар донор болон олон улсын байгууллагуудтай байнга зөвлөлддөг болно.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, СУРГАМЖ

Анхны хөгжлийн банкууд 1930-аад онд үүсч бий болсон бол 1950-иад оноос колоничлол задран унаж, шинэ улсууд тусгаар тогтнолоо зарлаж, улмаар үндэсний хэмжээний болон олон талт хөгжлийн банк олноор байгуулагдах болов. Тусгаар тогтнолоо дөнгөж олсон, хөгжиж буй орнуудын хувьд эхэн үедээ хөгжлийн банкууд нь тухайн улсын аж үйлдвэрлэл, худалдааг эрчтэй хөгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байв. Улмаар засгийн газар хоорондын, түүнчлэн бүс нутаг дамнасан үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагууд (Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк гэх мэт) үүсэн бий болж, үндэсний хөгжлийн банкуудтай холбогдон ажиллах болов.

1960-аад оны үед түгээмэл байсан аж үйлдвэржүүлэх, импортыг орлох зэрэг уриа лоозонтой хөгжлийн банкны чиг хандлага өөрчлөгдөж, нийгмийн хөгжлийг дагасан шинэ зорилтууд гарч ирэв. Тухайлбал, экспортыг дэмжих, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүү зээлийн шинэ дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажиллагаа эхэлсэн байна. Харамсалтай нь 1970, 1980-иад онуудад үндэсний хөгжлийн банкууд олноороо дампуурч хаалгаа барьснаас үүдэн ийм байгууллагуудын ирээдүй бүрхэг болов. Хөгжиж буй орнуудад хөгжлийн банк болон төрийн өмчит банкууд нь хөгжил дэвшил авчрах нь байтугай санхүүгийн хямралыг үүсгэсэн тохиолдол ч гарчээ. Үүнээс болж олон оронд хөгжлийн банкийг хувьчилж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж, эсвэл үйл ажиллагааг нь бүрмөсөн зогсоож байв.²

Мэдээж санхүүгийн хямрал хөгжлийн банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсан ч гол асуудал нь ийм төрлийн байгууллага дахь засаглал болон удирдлага менежменттэй холбоотой дутагдал байв. Тухайлбал, Өмнөд Ази, Латин Америк, Африк тивийн Сахарын цөл хавийн орнууд дахь хөгжлийн банкуудын дийлэнхид чанаргүй зээлийн нь нийт багцад эзлэх хувь 50 хүртэл байх тохиолдол түгээмэл байжээ³. Үүнээс улбаалан олон улсын санхүүгийн байгууллагууд хөгжлийн санхүүгийн байгууллагуудад олгодог зээлийнхээ хэмжээг 1990-ээд оны эхнээс эрс бууруулсан ажээ⁴.

Нөгөө талаар, Зүүн Азийн орнуудын хөгжлийн банкуудын үйл ажиллагаа нь бусад бүс нутаг дахь хөгжлийн банкуудтай харьцуулах юм бол илүү амжилттай явж ирсэн байна. Зүүн Азийн хөгжлийн банкуудын амжилтын нууц нь тэдний үйл ажиллагааг аль болох улс төрөөс ангид байлгах гэж засгийн газрууд нь хичээсэн, нөгөө талаар зээлийн төсөл бүрийг бодитойгоор дүгнэх, үнэлэх, хянах хөшүүрэг, механизмыг бий болгож чадсанд оршино. Жишээ нь, Япон болон Сингапурын хөгжлийн банкууд нь засгийн газраас авсан мөнгөө эргүүлж өгөхдөө хүү төлдөг байсан нь банкны удирдлагаас хамгийн бодитой, эргэж төлөгдөх төслүүдийг л санхүүжүүлэх нэг хөшүүрэг болж байв.

Хөгжлийн банкуудыг дампуурахад хүргэдэг үндсэн шалтгаанууд нь:

- Хөгжиж буй орнуудын засаглал нь сул байсан, нөгөө талаар ийм төрлийн банкны хувьд удирдлага, санхүү, үйл ажиллагааны тал дээр мэдлэг, чадвартай боловсон хүчин хомс байсан явдал.
- Улс төрийн нөлөөлөл их байдгаас шалтгаалан тухайн засгийн газрыг дэмжигчид нь зээлийн ихэнхийг авах нь түгээмэл байсан.
- Хөгжлийн банкны менежментийг сайн хийж чадаагүй,

зохицуулалт муу байсан, нөгөө талаар арилжааны зарчмаар ажиллаж чадаагүй явдал.

- Хөгжлийн банкны тавьдаг зорилго нь их явцуу, зарим тохиолдолд оновчтой бус байсан, түүнчлэн тус байгууллага нь тухайн улс орны санхүүгийн тогтолцооны нэг хэсэг бололгүйгээр бие даасан, салангид үйл ажиллагаа явуулсан.
- Хөгжлийн төлөөх зорилго нь санхүүгийн хувьд үр өгөөжтэй, зардлаа нөхдөг байх гэсэн зарчимтай олон тохиолдолд зөрчилдөг байсан явдал. (Өөрөөр хэлбэл, хөгжлийн банкуудын хувьд санхүүгийн өгөөж нь маш бага мөртлөө нийгмийн хөгжилд тустай төсөл хөтөлбөрүүдийг зээлжүүлэх нь амаргүй байв⁵.)
- Зах зээлийн түвшингээс доогуур хүүтэй зээл олгох ба энэ нь хувийн салбарын зээлдүүлэгчдэд нөлөөлөх зэрэг ажээ. Өөрөөр хэлбэл, арилжааны банкуудаас эрс бага хүүтэй зээлийг олгох нь тэдний урт хугацааны, тогтвортой үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

Дээрх шалтгаануудаас болж чанаргүй зээлийн тоо ихсэх, зээлийн эргэн төлөлт муудах, улмаар засгийн газраас байнга дэмжлэг, татаас авах зэрэг нь хөгжлийн банкны үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг байна. Ийнхүү сүүлийн хорин жилийн туршид хөгжлийн банкуудын үзүүлдэг үйлчилгээ, хамрах хүрээ, засаглал, удирдлагын тогтолцооны хувьд өргөн хэмжээний өөрчлөлт явагдаж иржээ. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, арилжааны зарчмаар ажиллах механизм бүрдүүлэх, засгийн газраас гадна өөр хөрөнгө оруулагчдыг татах, хувьчлах, хэсэгчлэн хувьчлах, удирдлагын тогтолцоог шинэчлэх, үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод болгох гээд олон ажил хийгдэж байгаа аж. Жишээлбэл, улс орноо аж үйлдвэржүүлэх, эдийн засгийн хөгжлийг хурдасгах зорилготойгоор 1954 онд байгуулагдсан Солонгосын Хөгжлийн Банк нь өнөөдөр өөрийн үндсэн үүргээ биелүүлсэн гэж үзэж байгаа ажээ⁶. Санхүүгийн зах зээл өөрчлөгдөж, өрсөлдөөний түвшин хүчтэй нэмэгдэж буйтай холбогдон тус улсын засгийн газар нь Хөгжлийн банкаа олон улсын түвшинд далайцтай үйл ажиллагаа явуулах, улмаар дэлхийд өрсөлдөх чадвартай санхүүгийн институт болгох зорилго дэвшүүлээд байна. Энэхүү амаргүй зорилгод хүрэх, цаашилбал дэлхийн хэмжээний тоглогч болгохын тулд Солонгосын засгийн газраас Хөгжлийн банкийг хувьчлах шийдвэр гаргаад байна.

Амжилттай явж ирсэн цөөн тооны хөгжлийн банк бий. Үүний нэг нь 1968 онд байгуулагдсан Сингапурын хөгжлийн банк (СХБ) бөгөөд өнөөдөр тус байгууллага тус улсын хамгийн том арилжааны банк болж, Ази тив болон Ойрхи Дорнодын 16 оронд салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүссэн цагаасаа эхлэн тус банк нь Сингапурын компаниудад шаардлагатай санхүү зээлийн үйлчилгээг үзүүлж, тэдний өсөлтөд томоохон түлхэц үзүүлжээ. Сүүлийн үед жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ч санхүүгийн үйлчилгээ хүргэх болсон байна. СХБ-ны үндсэн үйл ажиллагаа Сингапур, Хонг Конгт төвлөрөх бөгөөд 2009 онд тус банкны цэвэр ашгийн 57 болон 22 хувь нь тус хоёр зах зээлд харгалзан ногдож байв⁷. Дээрх хоёр оронд л гэхэд СХБ нь таван сая гаруй хэрэглэгчдэд банкны үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн зээл, мортгейж, үл хөдлөх хөрөнгийн санхүүжилт чиглэлээр ч мөн амжилттай үйл ажиллагаа явуулдаг болсон байна. Тухайн эдийн засаг, нийгмийн хөгжилд хөл нийлүүлэн алхаж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанарыг байнга сайжруулж, эрүүл

² Future role of national development banks in the twenty-first century, N. Bruck, 2005

³ "Evolving role of national development banks in East Asia", Jennifer Amyx and A.Maria Toyoda, 2006.

⁴ Rethinking the Role of National Development Banks, UN DESA, 2005

⁵ A macro-framework for successful development banks, Janine Thorne and Charlotte du Toit, 2009

⁶ www.kdb.co.kr

⁷ www.dbs.com

зөв удирдлагатай явах юм бол амжилтад хүрч болохын нэг жишээ нь СХБ болов уу.

Харамсалтай нь, СХБ-ны яг эсрэг дүр зургийг илтгэх хөгжлийн банкууд олон байсан бөгөөд тэдний ихэнх нь өнөөдөр үйл ажиллагаа зогсоосон. Хамгийн сүүлийн үеийн жишээнд Бахамын Хөгжлийн банкныг дурдаж болох юм. 1978 онд Бахамийн засгийн газар нь зуун хувь төрийн өмчлөлөөр хөгжлийн банк байгуулсан бөгөөд үндсэн зорилго нь тус улсын эдийн засгийн гол салбар болох ХАА, загас агнуур, аялал жуулчлал, аж үйлдвэр, үйлчилгээ, тээврийн салбарыг зээл, санхүүжилтаар хангах явдал байв. Тус банкныг засгийн газрын зүгээс Бахамийн аж үйлдвэржилт, ХАА, худалдааны хөгжлийг дэмжих гол байгууллага хэмээн үзэж байсан аж. Эдийн засгийн хувьд үр ашигтай төслүүдийг дэмжих замаар энэхүү банк нь ажлын байр шинээр үүсгэх, импортыг багасгаж, экспортыг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, улмаар бүх Бахамчуудын амьдралыг өөд нь татах үүрэг хүлээсэн байв.

Тэгвэл өнөөдөр Бахамийн хөгжлийн банк нь дампуурлын ирмэгт тулаад байна. Сүүлийн арван жилийн туршид үйл ажиллагаа нь доголдож ирсэн тус банкинд чанаргүй, найдваргүй зээлийн хувь хэмжээ нийт багцын 50 хувьд хүрсэн бөгөөд цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулахад маш бэрхшээлтэй болжээ⁸. Бүтэц, зохион байгуулалтын буруу системтэйгээс гадна банкны удирдах ажилтнуудын зүгээс эдийн засгийн хувьд үр өгөөжгүй төслүүдэд зээл олгож ирсэн нь энэ байгууллагыг нуран унахад хүргэсэн байна. Захирал, ТУЗ-ын гишүүд, менежерүүд нь улстөрчид, найз нөхөд, хамаатан садангийн хүмүүсийнхээ нөлөөнд автаж мөнгийг замбараагүй цацжээ. Харамсалтай нь, энэ байдлын хариуцлагыг үүрэх хувь хүн байхгүй бөгөөд эрсдэлийг засгийн газар өөртөө ногдуулахаас өөр зам үлдсэнгүй.

Хэдийгээр тус улсын парламентаас тусад нь хууль гарган тус банкныг байгуулсан боловч эдийн засгийн хөгжлийг дэмжих, сайжруулах гэсэн том зорилгоо биелүүлэхийн тулд бүтэц зохион байгуулалт, удирдлага, засаглалын тогтолцоогоо эргэн харах хэрэгтэй болоод байна. Түүнчлэн хөгжлийн банкны хуулийг ч гэсэн өөрчлөн шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа ажээ. Тухайлбал, уг хуульд зааснаар тус улсын Сангийн Яам, тэр дундаа Сайд нь удирдах зөвлөлийн дарга болон гишүүдийг дангаараа томилдог байна. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай, эсвэл хамтарсан аж ахуйн нэгжүүдэд зээл олгохыг хориглодог ажээ.

ЗӨВЛӨМЖ

Олон улсын туршлага, сургамжаас харахад засгийн газрын зүгээс дараах асуудлуудад онцгой ач холбогдол өгч, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

1. Хөгжлийн банк байгуулах үндэслэл, хэтийн зорилго, зорилтуудыг оновчтой дэвшүүлэн тавих

- Хөрөнгийн зах зээл либеральчлагдаж, мөнгөний урсгал нэмэгдэж буй өнөө цагт хөгжлийн банк нь хувийн хэвшилтэй өрсөлдөхгүйн тулд маш тодорхой хэтийн зорилготой байх ёстой. Өөрөөр хэлбэл, явуулах үйл ажиллагаа нь тодорхой салбарууд дээр л төвлөрч, хувийн хэвшил хангалттай түвшинд хийж байгаа зүйлсийг хийх шаардлагагүй юм. Тухайлбал, Германы KfW банк нь жижиг дунд бизнес, орон сууцны санхүүжилт, байгаль орчин болон олон улсын хөгжлийн чиглэлүүд дээр төвлөрөн ажилладаг байна. Нөгөө талаар, хэтийн

зорилго нь тодорхой байх тусам хөгжлийн банк нь эргэж төлөгдөхгүй, муу төслүүдийг санхүүжүүлэх магадлал нь багасах ажээ.

- Хөгжлийн банкны үүрэг, чиглэл цаг хугацаа өнгөрөх тусам хувьсан өөрчлөгдөж өөр хэлбэрт шилжих, эсвэл хувьчлагдаж болно (Япон, Сингапурын хөгжлийн банкны жишээ). Тиймээс эхнээсээ алс хөдтээ тус байгууллагын бүтэц, зохион байгуулалт ямар байхыг бодитойгоор тодорхойлсон байх тусам сайн. Ингэж чадаагүй тохиолдолд, хөгжлийн банкны урт хугацааны, тогтвортой үйл ажиллагааг хангахад амаргүй.
- Хөгжлийн банкны үйл ажиллагаа нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк гэх мэт олон улсын санхүүгийн байгууллагуудаас үзүүлдэг зээл, тусламжаас хэрхэн яаж ялгарахыг тодорхойлох. Эдгээр олон талт байгууллагуудын хийхгүй байгаа, эсвэл хийж чадахгүй байгаа ямар ажлыг хийх вэ гэдгийг тооцох нь зүйтэй. Энэ нь үйл ажиллагааны давхардал, үр ашиггүй өртөг зардлаас зайлсхийх боломжийг бий болгоно.
- Гарч болох улс төрийн болон эдийн засгийн эрсдэлүүдийг тооцох ёстой. Нөгөө талаар, хөгжлийн банкны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр байгаа эсэх, банк болон засгийн газрын хоорондын хамтын ажиллагааг хэрхэн зохицуулахыг шийдсэн байвал зохино.
- Ядуурлыг бууруулах зорилтуудтай хөгжлийн банкны зорилго, үйл ажиллагаа уялдах нь зохистой. Өөрөөр хэлбэл, ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх гэсэн засгийн газрын урт болон дунд хугацааны зорилгуудыг бодит ажил хэрэг болгоход хөгжлийн банк ямар үүрэг гүйцэтгэхийг тодорхойлох нь чухал. Нөгөө талаар, энэ нь засгийн газрын бусад агентлаг, үйл ажиллагаатай хөгжлийн банк хэрхэн холбогдох, хамтран ажиллах зарчмыг тогтооход ч ач холбогдолтой.

2. Хөгжлийн банкнаас хувийн хэвшилд үзүүлэх нөлөө

- Засгийн газрын зүгээс хөнгөлттэй нөхцөл эдлэх хөгжлийн банк нь өөрийн хөрөнгөөр, бүх эрсдэлээ хариуцан ажиллаж буй арилжааны банкны үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг сайтар тооцоолох хэрэгтэй. Тухайлбал, хөгжлийн банк байгуулагдахад өндөр ур чадвар, туршлага бүхий мэргэжилтнүүдийг олж авах тал дээр арилжааны банкуудтай өрсөлдөнө. Тэгэхээр, нэг талд ур чадварын хомсдол үүсэх магадлалтай.
- Үйл ажиллагаа, үйлчилгээ нь зах зээлийн горимоор явагддаг, хөрөнгө оруулагчдын тоо, төрлийг нэмж чадсан, ухаалаг, оновчтой засаглалын тогтолцоотой хөгжлийн банк амжилттай явж чадахыг Сингапурын Хөгжлийн банкны туршлагаас харж болно.

3. Хөгжлийн банкны хууль эрх зүйн орчныг бий болгох

- Хөгжлийн банк нь харьцангуй амжилттай үйл ажиллагаа явуулсан улс орнууд ийм байгууллагад зориулсан хуулийг тусад нь гаргаж өгсөн байдаг. Гэхдээ тусгай хуулийг батлаж гаргаснаар бүх асуудал зөв тийшээ шийдэгдэнэ гэж хэлэх боломжгүй. Хамгийн гол нь ийм хууль маш тодорхой заалтуудтай, тэдгээр нь банкныг удаан хугацааны туршид эдийн засгийн хувьд тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж олгосон байх ёстой.
- Хөгжлийн банкинд зориулан хууль гаргах нь ийм төрлийн байгууллагын хувьд хувийн хэвшлийн зүгээс хэрэгжүүлэх боломжгүй ч эдийн засаг, нийгэм, байгаль орчны хувьд далайцтай үр нөлөө бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эрхэм зорилготой нь холбоотой ажээ. Өөрөөр хэлбэл, санхүүжилтын эх үүсвэр нь татвар төлөгчдийн хөрөнгө байдаг, нөгөө талаас хадгаламж авдаггүй тул арилжааны банкны хуулиар

⁸ <http://www.bahamasb2b.com/news/story.php?title=corruption-and-incompetence-hit-bahamas-development-bank>

⁹ http://laws.bahamas.gov.bs/statutes/statute_chapter_357.html

санхүүгийн ийм байгууллагыг зохицуулах аргагүй юм.

- Хөгжлийн банкны хуульд тус байгууллагын зорилго, зорилт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо, ТУЗ болон гүйцэтгэх багийг томилох явц ба тэдний эрх үүрэг, хяналтын тогтолцоо, өмчлөл, хувьцаа эзэмшигчид, тусгай сангууд байх эсэх, дотоод журам, ногдол ашиг зэрэг олон асуудлыг нарийвчлан тусгадаг байна.
- Нөгөө талаар, хөгжлийн банк нь жижиг дунд бизнесийг дэмжих сан гэхчлэн зөвхөн төв банк юмуу аль нэг яаманд харьяалагдах ямар нэг данс биш, засгийн газрын шийдвэрээр байгуулагдах бие даасан институт болохын хувьд тодорхой хууль, эрх зүйн орчинтой байх хэрэгтэй аж.
- Саяхан батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 17-р зүйлд засгийн газар нь төрийн өмчит хөгжлийн банкны урт хугацаат үнэт цаасыг худалдан авна гээд, тус банкны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн төрлийг нэрлэсэн хоёр хэсэг заалт оруулжээ. Түүнчлэн, 17.5-д төрийн өмчит хөгжлийн банк нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг сонгон санхүүжүүлэхдээ Банкны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг баримтална гэжээ. Энэ бүхнээс харахад, засгийн газар нь хөгжлийн банкны үйл ажиллагааг өнөөгийн хууль, тогтоомжид багтаан зохицуулах боломжтой гэж үзсэн бололтой. Гэвч бусад олон орны туршлага, жишээнээс харахад, нөгөө талаар дээр дурдсан нөхцөл байдлуудыг тооцон үзэхэд манай улсын хувьд хөгжлийн банкны хууль гаргах нь энэ байгууллагын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд ач холбогдолтой болохыг зөвлөж байна.

4. Засаглал болон удирдлагын асуудлыг оновчтой шийдэх

- Хөгжлийн банк нь өдөр тутмын үйл ажиллагаагаа засгийн газраас хамааралгүй явуулах нь амжилтын үндэс болдгийг олон орны жишээнээс харж болно. Эсрэг тохиолдолд, хөгжлийн банк нь буруу тийш эргэх нь бараг л баталгаатай. Тийм учраас удирдлагын тогтолцоог аль болох оновчтой, зөв механизмаар байгуулах хэрэгтэй аж. Тухайлбал, бие даасан ТУЗ байгуулах нь зүйтэй бөгөөд гишүүдийн дийлэнх нь хувийн хэвшлээс байх. Түүнчлэн иргэний нийгмийн төлөөллийг ч оруулж ирж болно.
- ТУЗ-ын гишүүд нь нийгэм, эдийн засгийн хөгжил, санхүү, бизнес, банк, удирдлага менежментийн чиглэлээр арвин туршлагатай байхаас гадна улс төрийн нөлөөллөөс ангид байхаар сонгох ёстой. Улс төрийн шалгуураар гишүүдийг оруулж ирэх нь эрсдэлийг нэмэгдүүлэх аюултай.
- Эрсдэлийн менежментийн зохистой тогтолцоог бий болгох, зээлийн бодлого ил тод байх, түүнчлэн бие даасан аудитын систем маш чухал. Эдгээрийг сайн хийж чадахгүй бол зээлийн эргэн төлөлт урт хугацаандаа муудах эрсдэл гарч ирдэг ажээ.
- Өмчлөлийн эх үүсвэрийг олшруулах нь чухал. Дан ганц төрийн өмчид тулгуурлах нь эрсдэлийг эрс нэмэгдүүлнэ. Тухайлбал, Кенийн хөгжлийн банкны өмчлөгчид нь тус улсын засгийн газраас гадна Британийн CDC, Германы хөгжлийн банк DEG, Голландын FMO болон Олон Улсын Санхүүгийн Корпорац болох IFC нар ажээ.
- Банкны үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд ил байна. Жилийн тайланг боловсруулан гаргаж, олон нийтэд хүргэх, Интернет дээр тавих асуудлыг дүрмэнд оруулах.
- Үр дүнг хэмжих маш тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж тавих нь зүйд нийцнэ. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчдийн хөрөнгөөр ямар ажил хийсэн, энэ нь

хөгжилд чиглэсэн ямар асуудлыг шийдэж байгаа нь олон нийтэд ил тод, ойлгомжтой байх ёстой.

5. Нийгэмд авч ирэх эерэг нөлөөллийг тодорхойлох

- Хөгжлийн банкны хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр өгөөжийг үнэлэхээс гадна тухай төслийг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засаг, байгаль орчинд гарах эерэг үр нөлөөг ч тооцох ёстой. Хувийн бизнес ашгийн төлөө гэсэн зарчмаар хэрэглэгчдэд тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэдэг. Харин татвар төлөгчдийн мөнгөөр бий болж, хөгжлийн төлөөх төслүүдийг хэрэгжүүлснээр гарах үр өгөөж, эерэг нөлөөлөл нь аль болох тодорхой, бодитой, үзэгдэж харагдахуйц байх ёстой. Хөгжлийн төлөө сайхан нэрийн дор үр нөлөө нь хэзээ гарах мэдэгдэхгүй төслүүдийг санхүүжүүлэх нь дампууралд хүргэдгийг олон жишээнээс харж болно.
- Түүнчлэн хөгжлийн банк нь тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжиж, авилга, хээл хахуулиас ангид байх ёстой. Хөгжлийн банк нь олон нийт, хувийн хэвшилд үлгэр жишээ болохуйц зарчмуудыг баримтлах нь хамгаас чухал. Ингэж чадахгүй тохиолдолд, дотооддоо олон нийтийн итгэлийг хүлээхгүйгээс гадна олон талт донорууд, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах боломжгүй болох аюултай ажээ.

6. Хувийн хэвшлээс суралцах

- Удирдлага, зохион байгуулалтын оновчтой механизм, тогтвортой ажиллагааны хөшүүргийг хувийн хэвшилд дэх шалгарсан туршлага, загвар дээр үндэслэн бий болгох хэрэгтэй. Компанийн засаглал, гүйцэтгэх удирдлагатай хийгдэх гэрээ, үйл ажиллагааг нь үнэлэх маш тодорхой шалгууруудыг гаргахдаа хувийн хэвшлийн шилдэг практикийг ашиглахгүй бол манай улсад өмнө нь байсан төрийн өмчит банкуудын гунигт хувь заяа давтагдах эрсдэлтэй. Нөгөө талаар, олон нийт, татвар төлөгчид данхар бүтэцтэй, засгийн газрын нэг агентлаг шиг ажилладаг байгууллага дахин шинээр байгуулахыг хүлээн зөвшөөрөхгүй.
- Үйл ажиллагаа, үйлчилгээгээ зах зээлийн горимоор явуулбал зохистой. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн үйлчилгээн дээр эрэлт, нийлүүлэлтийн хуулийг баримтлах, үр ашиггүй, зардлаа нөхөхгүй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхгүй байх, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг гаргах, хөгжлийн банк гэдэг нэрийн дор хүнд суртлын аппарат үүсгэхгүй байх зэрэг нь онцгой чухал.

7. Хөгжлийн төслийн гарах үр нөлөө ба эргэн төлөгдөх нөхцөл хоёрыг тэнцвэржүүлэх

- Өөрөөр хэлбэл, хөгжилд тустай боловч эдийн засгийн үр өгөөжгүй төслүүдийг санхүүжүүлээд эхэлбэл тус байгууллага дампуурсан төрийн өмчит банкуудын араас орно. Бусад улс орны жишээг харахад ч гэсэн үр ашиг муутай төслүүдийг хөгжлийн төлөө гэдэг сайхан үгийн халхавч дор зээлжүүлэх нь яваандаа хөгжлийн банкныг унагаадаг ажээ. Тэгэхээр нийгэм, эдийн засаг, ядууралтай холбоотой бусад үр өгөөжөөс гадна санхүүгийн тогтвортой байдал нь ямар ч төслийн хувьд амин чухал.
- Тиймээс эдийн засгийн үр өгөөж нь тодорхой хугацааны дараа гарч ирэх, гэхдээ өнөөдрийн байдлаар хувийн хэвшил дангаараа шийдэх боломжгүй төслүүдийг маш нухацтай авч үзсний үндсэн дээр хөгжлийн банк хэрэгжүүлэх эсэхээ шийддэг механизм онцгой чухал юм. Үүний тулд, өнөөдөр үйл ажиллагаа нь амжилттай явагдаж буй гадаадын хөгжлийн банкуудын туршлагаас суралцаж, ажилдаа нэвтрүүлэх шаардлагатай.